# Л.ПҮРЭВСҮРЭН САЙД ХИЛИЙН ЧАНАД ДАХЬ МОНГОЛЧУУДТАЙГАА ЗОЛГОВ

Written by hanoi
Wednesday, 17 February 2016 02:03 -

There are no translations available.



Хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдэд хандсан “Дэлхийн Монголчууд” дунд хугацааны хотолбор Засгийн газраас батлагдсантай холбогдуулан Гадаад хэргийн сайд Л.Пvрэвсvрэн Гал бичин жилийн шинийн наймны одор хилийн чанад дахь Монгол Улсын дипломат толоологчийн газрууд болон монголчуудын холбоодын толоололтэй цахим уулзалт хийж, сар шинийн мэндчилгээ дэвшvvллээ. Уулзалтад гадаадын 24 улсад оршин суугаа монголчууд оролцлоо.

Л.Пvрэвсvрэн сайд энэхvv цахим уулзалтад оролцогчдод  Засгийн газрын энэ оны анхдугаар хуралдаанаар баталсан “Дэлхийн Монголчууд” хотолборийн vндсэн зорилтуудыг хэрэгжvvлэхэд хилийн чанадад суугаа монгол иргэд болон тэдний холбоодын vvрэг, санаачилга, хамтын ажиллагаа чухал болохыг онцлон тэмдэглэж, хотолборийн талаар товч мэдээлэл хийв.

Уулзалтад оролцсон монгол иргэд “Дэлхийн Монголчууд” хотолборийн хvрээнд хvvхдvvдээ эх хэл, соёлыг зааж сургах, сурах бичгээр хангахад санхvvгийн дэмжлэг vзvvлэх, хилийн чанадад осч торнисон монгол оюутан залуусыг эх оронд нь дадлага хийлгэх асуудлыг бодлогын тvвшинд тавьж шийдвэрлэхэд Гадаад хэргийн сайдаас дэмжлэг vзvvлэхийг хvсэхийн сацуу монгол иргэдийн зохион байгуулж байгаа арга хэмжээ, санаачилгыг санхvvжvvлэх боломж, нохцолийн талаар саналаа хуваалцлаа.

Уг цахим уулзалтыг цаашид холбогдох торийн болон торийн бус байгууллага, судлаачдыг оролцуулан тодорхой сэдвээр сар бvр зохион байгуулахаар толовлосон байна.

Энэ удаагийн Гадаад хэргийн сайдын хилийн чанадад суугаа иргэдтэйгээ хийсэн уулзалтад яамны холбогдох ажилтнуудаас гадна “*Хилийн* чанад дахь Монголчуудын *зөв лөл” ТББ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Б.Мөнхдөл,*
Цахим ортоо холбоо ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга Ч.Лодойравсал нар оролцов.